



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/152

Хэрлэн сум

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
зөвлөлийн бүрэлдэхүүнд шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2025 оны 01 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дүрмийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн байгуулсугай

Зөвлөлийн

дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн

дарга:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй
байдал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга

Байгаль орчны газрын дарга

Нийгмийн даатгалын газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

Эрүүл мэндийн газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Багануур Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ
Төрийн өмчит хувьцаат компанийн харьяа Хэнтий аймаг
дахь салбарын дарга

Бор-Өндөр сумын Уулын баяжуулах үйлдвэрийн
Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл (тохиролцсоноор)


М-Агро ХХК (тохиролцсоноор хувийн хэвшил)

2.

2.Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/64 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

[illegible][illegible]

الحمد لله رب العالمين ..

